

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор:
М.Нарантуяа

Утас: 70518396, 99029193

Цахим хаяг:
narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123, 99035990

Цахим хаяг:
davaag@audit.gov.mn

Ахлах аудитор:
Н.Болдбаатар

Утас: 70512123, 88039069

Цахим хаяг:

boldbaatar@audit.gov.mn

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дуусгавар болсон тайлан

БАРУУН-УРТ
2018 он

Агуулга

| | |
|---|----|
| Аудитын гэрчилгээ | 4 |
| 1 Аудитын тайлан | 6 |
| 1.1 Оршил | 6 |
| 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 6 |
| 1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 7 |
| 1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 7 |
| 1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 8 |
| 1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 8 |
| 1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 9 |
| 1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл | 10 |
| 1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 11 |
| 1.9.5 Аудитаар илэрсэн материаллаг зөрчилд тооцогдох, цаашид анхаарвал зохих зөрчил, дутагдал | 12 |
| 1.9.6 Төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах санал | 14 |
| 1.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 14 |
| 1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 14 |
| 2.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал | 16 |
| 2.2 Авлагын бүртгэл, тайлагнал | 17 |
| 2.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал | 18 |
| 2.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал | 19 |
| 2.5. Өр төлбөрийн бүтцийн талаар | 20 |
| 2.6 Орлого, татаас санхүүжилтийн талаар | 21 |
| 2.7 Зарлагын талаар | 22 |
| 2.8 Хуримтлагдсан үр дүнгийн талаар | 24 |
| 2.9 Эзэмшигчийн өмчийн талаар | 24 |
| 3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа төсвийн захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар: | 24 |
| 4. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 24 |
| 5. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх санал дүгнэлт: | 25 |

| | | |
|----|--|------------------------------------|
| 6. | ҮАГ болон Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна..... | 25 |
| 7. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 26 |
| 8. | Менежментийн захидал | 33 |
| | Төсвийн төлөвлөлт, орлого | Тэргүүлэх ач холбогдол № 1..... 34 |
| | Санхүүгийн тайлангийн тодруулга, дотоод хяналт | Тэргүүлэх ач холбогдол №2 35 |
| | Төсвийн зарцуулалт, тайлагнал | Тэргүүлэх ач холбогдол №3 36 |
| 9. | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл..... | 38 |
| 1. | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 38 |
| 2. | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 41 |
| 3. | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 45 |
| 4. | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 50 |
| 5. | Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 52 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| АИТХ | Аймгий иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| БТСГ | Биеийн тамир спортын газар |
| ЗГТС | Засгийн газрын тусгай сан |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СХААлба | Санхүү хяналт аудитын алба |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| БСШУСЯ | Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЕЗНТ | Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайлан |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТӨААТҮГ | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭЭС | Эргэлтийн эмийн сан |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ЖМС | Жижиг мөнгөн сан |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2018.04.20 № 188
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Т.АМАРБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,750.6 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн, энэ нь бид бүхний олж тогтоосон материаллаг түвшнээс 1,603.6 сая төгрөгөөр хэтэрсэн, орон нутгийн төсвийг хэтрүүлэн зарцуулсан, төсвийн гүйцэтгэлийг дутуу тайлагнах нөхцөл байдал үүссэн, сумдын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг холбогдох заавар журмын дагуу толилуулаагүй, төсөвт хохирол учруулсан байх гэмт хэргийн шинж чанартай зөрчил дутагдал илэрсэн, Эмийн эргэлтийн сангийн орлого, зарлага аудитаар баталгаажаагүй, 5 төсвийн шууд захирагч, 1 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан, 4 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд стандарт бус санал дүгнэлт өгсөн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаар хураангуйлан дор тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлж, Сүхбаатар аймгийн ТЕЗ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 03-20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор А.Мөнхцэцэг, Б.Мөнхбамбар, О.Барчидгүнсэн, Ө.Золзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018.03.30-нд төрийн аудитын байгууллагад 6/357 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сүхбаатар аймгийн Засаг дарга “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах стратегийг төлөвлөх, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж дүгнэх, нутгийн захиргааны байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах, төрийн албаны стандартыг хангуулах, иргэдэд захиргааны үйлчилгээг үзүүлэх замаар аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилго дэвшүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;” заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг дарга нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээллийг аудитын төлөвлөлтийн үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, ТБӨНӨХБАҮХАТ, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын тогтоол шийдвэр, Сангийн сайдын тушаал болон бусад эрх зүйн акт, стандартын хүрээнд бүртгэлийн бодлого, журмаа тодорхойлж, санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримталсан байна.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэхдээ санхүүгийн Э-Тайлан программ хангамж ашиглагджээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төсвийн тухай хуулийг зөрчиж төсвийн түр горимыг буруу хэрэгжүүлсэн, хүчин төгөлдөр бус тогтоол шийдвэрээр төсөв зарцуулсан, сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагч Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн тодотголыг боловсруулж батлуулаагүй, тодотгол хийх нөхцөл байдал үүсээгүй байхад орлого, зардлыг тодотгосон, нэгтгэсэн тайланд хамрагдсан төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд илэрсэн зөрчил дутагдал, балансын хүчин зүйлд нөлөөллийн дүн шинжилгээ хийж материаллаг байдлын суурь үзүүлэлтийг зардлаар сонгох нь зүйтэй гэж үзэв.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 57,361.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,147.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр эрсдэлтэй асуудалд горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

| /сая төгрөгөөр/ | | | | |
|-----------------|--|-----|---------|---------|
| № | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн | Тайлбар |
| 1 | Зөвлөмж болгосон асуудал | 205 | 3,317.6 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 44 | 251.8 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 40 | 905.4 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 24 | - | |
| Дүн | | 313 | 4,474.8 | |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягт болон хавсралт судалгааны хамт нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт толилуулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар дараах заалтад ангилан харуулав. Үүнд:

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

ТЕЗ-ийн багц болон хяналтад байгаа аудит хамрагдсан төрийн сан, төсөвт байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 251.8 сая төгрөгийн 44 актыг тогтоосон. Зөрчлийг утгаар нь авч үзвэл гэрээний дагуу газар, хашаа худалдан борлуулсны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүү гэрээнд заасан хугацаандаа төлөгдөөгүй, төсвийн хэмнэлтэд тооцогдохгүй төсвийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй материал нөөцөлсөн, төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд эзэлж байна. Төлбөрийн актын 11.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, 32.7 сая төгрөгийг төсөл сан, 207.6 сая төгрөгийг төрийн сан болон төсвийн байгууллагад тогтоосон. Акт тогтоосон байгууллага, зөрчлийн утгуудыг нэгтгэн хавсралтаар толилуулав. /Хавсралт 1/

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

ТЕЗ-ийн багц болон хяналтад байгаа аудит хамрагдсан төрийн сан, төсөвт байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн аудитаар 905.4 сая төгрөгийн 40 албан шаардлага хүргүүлсэн. Үүнийг утгаар нь авч үзвэл төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан, анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаагүй, хөрөнгө материалыг тоолоогүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан, хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, бараа материалын тайлан гаргаагүй зэрэг зөрчлүүд байна. Албан шаардлагын 62.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, 842.9 сая төгрөгийг төрийн сан болон төсөвт байгууллагад хүргүүлсэн байна. /Хавсралт 2/

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Төсвийн, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, материаллаг шинж чанартай зөрчил гаргасан, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн 24 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд шатны төсөв захирагчид хүргүүллээ. Хууль тогтоомжид заасны дагуу зөрчлийн шинж чанартай нь тохирсон хариуцлагын арга хэмжээ авч ажиллахыг төсөв захирагч нарт албан шаардлагаар хариуцуулав. Хариуцлага ногдуулсан албан тушаалтны судалгааг хавсралтаар толилуулав. (Хавсралт 4)

1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сургуулийн өмчийг ашиглуулан, өөрийн байгууллагын чиг үүрэгт хамааралтай халаалтын ажил үйлчилгээг “Жигүүрт хүлэг” ХХК-тай гэрээ байгуулан, гүйцэтгүүлсэн. Мөн нүүрсний тээврийн үйлчилгээнд хөрөнгө мөнгө зарцуулах байтал тус компани руу түлш халаалтын батлагдсан төсвийг иж бүрэн хэмжээгээр гүйцэтгэлийг харгалзахгүйгээр төсвийн хөрөнгийг илүү шилжүүлж, төсөвт хохирол учруулсан байна. Тухайлбал: 2017 оны 09 дүгээр сард ашиглалтад орсон сургуулийн спорт заалыг 2016 онд орсон мэтээр түлш халаалтын төсөвт тодотгол хийж 85.6 сая төгрөг, 2017 оны эхний хагас жилд 48.9 сая төгрөг нийт 134.5 сая төгрөгийг гүйцэтгэгч компани болох “Жигүүрт хүлэг” ХХК руу илүү шилжүүлсэн зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 42 дугаар зүйлийн 42.3.1, 43 дугаар зүйлийн 43.5, 45 дугаар зүйлийн 45.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.1, 14.2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.
2. Мөн түлш халаалтын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэгч “Жигүүрт хүлэг” ХХК руу шилжүүлсэн санхүүжилт, зарцуулсан нүүрсийг материалын тайлангаар баримтжуулан үзэхэд 2016 онд 3386 тн нүүрс, 2017 онд 3834 тн нүүрс зарцуулсан байдаг. Аудиторын зүгээс АОУС-505-д заасны дагуу хөндлөнгийн тулган баталгаажуулалтыг бэлтгэн нийлүүлэгч “Талын гал” ХХК-тай хийхэд 2016 онд 683 тн нүүрс, 2017 онд 612.8 тн нүүрс бэлтгэсэн байдаг бөгөөд материалын тайлангаар тус бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас дээрх онуудад 7220 тн нүүрс бэлтгэсэн гэсэн хуурамч баримт бүрдүүлж, төсвийн хөрөнгийг 245.6 сая төгрөгөөр илүү шилжүүлж, хууль бус захиран зарцуулалт хийсэн үр дагавар бүхий зөрчил дутагдал оршиж байна. Энэ нь дээрх хууль тогтоомж болоод Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 45 дугаар зүйлийн 45.2.1 дэх заалтууд зөрчигдсэн байна.

Иймд дээрх зөрчил дутагдлуудтай Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3¹, АОУС-240 дүгээр стандарт “Залилантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлага”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 203 тоот тушаалын хавсралт “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.26 дахь заалтыг тус тус үндэслэн залилан, гэмт хэргийн шинжтэй зөрчил дутагдал илэрсэн учир холбогдох баримт материалыг бүрдүүлэн хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулахаар шийдвэрлэсэн болно.

¹ Төрийн аудитын байгууллагаас төсвийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит буюу тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн ашиглалт, зарцуулалтад аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрвэл энэ тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг шилжүүлэн шалгуулна.

1.9.5 Аудитаар илэрсэн материаллаг зөрчилд тооцогдох, цаашид анхаарвал зохих зөрчил, дутагдал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг шинж чанарын болон бүртгэлийн тодорхойгүй нөхцөл байдлуудтай холбогдох дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын тухайн жилд зарцуулах төсвийг тодотгон баталсан нь Төсвийн тухай хууль болон МУЗЗНДНТУ тухай хуульд заасны дагуу АИТХ-ын төлөөлөгчдийн 50-иас дээш хувийн санал авсан, албан ёсны хүчин төгөлдөр тогтоол болсон байдаг. Харин 2017 оны 12 сарын 21-ны өдөр төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах төсвийн тодотгол хэлэлцэж баталсан гэх боловч уг тогтоол нь Аймгийн ИТХ-ын тамга, тэмдэг, бусад зүйлсээр албан ёсны болж, баталгаажаагүй байдаг. Иймд Аймгийн ТЕЗ нь 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 03 тоот тогтоолоор төсвийг захиран зарцуулж, тайлагнах байтал, албан ёсны баталгаажаагүй тогтоолоор төсвийн орлого, зарлагыг 935.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.
- ✓ Аймгийн Засаг дарга 2017 оны төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3, 32 дугаар зүйлийн 32.2.11, 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангаагүй толилуулсан мөн АИТХ тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, 33 дугаар зүйлийн 33.2.5 дахь заалтыг баримтлаагүй төсвийг баталсан байна.
- ✓ Сумдын ТТЗ нар төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс дээр дурдсан зөрчил дутагдлууд гарч байна.
- ✓ Сумдын ТТЗ нар Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2²-д заасны дагуу төсвийн тодотгол хийх нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлоогүйгээр 362.6 сая төгрөгийн орлого, зарлагыг тодотгосон нь тус хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна. Мөн тодотгол хийхэд уг хуулийн 67 дугаар зүйлийн 67.2³-д заасны дагуу төсвийн танилцуулгыг бүрэн боловсруулж тодруулаагүй, төсвийн иж бүрэн бүрэлдэхүүнийг хангаагүйгээр төсвийг өргөн барьж байна.
- ✓ Бүх шатны ТТЗ болон ТЕЗ санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээ, зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаар танилцуулга бэлтгэж толилуулаагүй, мөн санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн боловсруулж тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг зөрчжээ.
- ✓ Сумдын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Эмийн эргэлтийн санг нэгтгэн толилуулсан байна. Бүх сумдын ЭЭС хуулийн цагалбарт хугацаанд аудитад хамрагдаагүй бөгөөд нийт дүнгээр борлуулалтын орлого 549.5 сая төгрөг, зарлага 523.1 сая төгрөг, нийт хөрөнгө 187.3 сая төгрөгөөр нэгтгэгдсэн байна. Уг нийт хөрөнгө, орлого, зарлагыг баталгаажуулах ажил хийгдээгүй учир үнэн зөв толилуулагдсан эсэхэд аудитаар баталгаа гаргаж өгөх боломжгүй болсон бөгөөд нэгтгэсэн тайланд бүртгэлийн тодорхойгүй нөхцөл байдал үүссэн. Мөн

2 Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

3 Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3.1-д заасны дагуу ТЕЗ-чид хамаарах бүх төсвийн байгууллага, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг хамруулахаар заасан байдаг. Гэтэл сумын ЭЭС-ууд хувьд шилжсэн, ХХК нэршлээр улсын бүртгэлд бүртгэгдсэн нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын хавсралт журмын 3.2, 3.3, 3.4, УСНББОУС-6 ийн 39-р заалтад заасны дагуу сумын ТТЗ-ийн эрх мэдэл, хяналтад байх чадамжгүй байгаа бөгөөд дээрх дүнгээр ТЕЗ-ийн нэгтгэл үнэн зөв толилуулагдаагүй байна.

- ✓ Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн төсвийн жил эхлэхэд аймгийн ИТХ-аар төсвөө батлуулаагүй нөхцөл байдал үүссэн. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/26 тоот захирамж гарч, Төсвийн тухай хуулийн 41.4, 41.6 дахь заалтуудыг үндэслэн төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй нөхцөл байдал үүсвэл төсвийн санхүүжилтийн түр горимыг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан боловч Төсвийн тухай хуулийн 41.4.1, 41.4.2 дахь заалтуудыг мөрдөлгүй цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг өмнөх оны түвшинд санхүүжүүлэхийг захирамжилсан нь уг хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн. Манай байгууллагаас дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй байхад 1,169.6 сая төгрөгийн төсвийг 2017 оны 01 дүгээр сард зарцуулж, Төсвийн тухай хуулийг зөрчсөн.
- ✓ Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаагүй “Мал хамгаалах сан”, “Байгаль хамгаалах” сангууд нэгтгэгдэж байна. Иймд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5⁴-д заасны дагуу дээрх сангуудыг ТЕЗ-ийн аль нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлж, нэгтгэх шаардлагатай байна.
- ✓ Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд 1,600.0 сая төгрөг баталсан. Үүнд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгосон 500.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл батлагдсан байдаг бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.8⁵ дахь заалттай нийцээгүй бөгөөд зарлагаар баталсан нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна. Мөн удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, зарлагын ангилалаар нэг бүрчлэн хэлэлцэж батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна. Төсвийн шаардлага, удирдлагын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөтөлбөр, арга хэмжээ бүрээр хэлэлцээгүйгээс төсөвт батлагдаагүй ОНӨҮГ-ын хэвийн үйл ажиллагааг хангах, үнийн зөрүүнээс үүссэн алдагдлыг нөхөхөд 80.0 сая төгрөг, зүүн бүсийн наадмын үйл ажиллагаанд 100.0 сая төгрөгийг зарцуулжээ. Удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр нэг бүрчлэн баталж өгөөгүйгээс нэг удаагийн шинж чанартай дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулал олгох, уралдаан тэмцээний үйл ажиллагаанд зарцуулах гэх мэт Төсвийн тухай хуульд нийцээгүй зарцуулалтыг гаргасан байна.

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

⁵ төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр

- ✓ Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын тухайн жилд зарцуулах төсвийг баталсан. Харин 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах төсвийн тодотгол хэлэлцэж баталсан гэх боловч уг тогтоол нь Аймгийн ИТХ-ын тамга, тэмдэг, бусад зүйлсээр албан ёсны болж, баталгаажгаагүй. Иймд уг төсвийн тодотгол нь хүчин төгөлдөр бус байгаа бөгөөд тус тодотголоор баталсан өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 20.0 сая төгрөг, сонгуулийн үр дүнгээр ажилгүй болсон иргэдэд төрөөс олгох тэтгэмжид 205.1 сая төгрөг, Аймгийн 75 жилийн ой, Баруун-Урт сумын 60 жил, Зүүн бүсийн хурд баяр наадмын зардалд 100.0 сая төгрөг, Баруун-Урт сумын иргэдийг хэрэглээний халуун усаар хангах зардлын зөрүү 56,6 сая төгрөг, “Дөрвөлж” ОНӨҮГ-ын хэвийн үйл ажилагааг хангахад усны үнийн зөрүү 80.0 сая төгрөг, төвлөрсөн системд холбогдсон зарим сумдад өвөлжилтийн бэлтгэл хангахад 46.5 сая нийт 508.2 сая төгрөгийн төсвийг батлуулаагүйгээр төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5⁶, 64 дүгээр зүйлийн 64.1.2⁷, 65 дугаар зүйлийн 65.1.1⁸ дэх заалтыг зөрчжээ.
- ✓ Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийг баталсан боловч тухайн жилд хэрэгжүүлэх аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг баталсан тогтоол шийдвэр нь хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болохыг тогтоосон байна.

1.9.6 Төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах санал

Төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах талаарх дараах санал гаргалаа. Уг саналыг ҮАГ-ын САГ-т хүргүүлж байна. Үүнд:

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр ирсэн боловсролын төсөвт албан байгууллагуудын хоол хүнсний зардал 42.3 сая төгрөг, түлш халаалтын зардал 131.0 сая төгрөгөөр хэмнэгдэх боломжтойг аудитаар тогтоосон болно. Уг төсвийн тооцоололтой холбоотой асуудлыг аудитаар баримтжуулсан.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аймаг орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөр үйл ажиллагааг батлуулан, төсвийг захиран зарцуулсан байдал, төсвийн тухай хуулийг зөрчсөн дээрх үйлдлүүд давтагдан гарах магадлалтай байгаа учир дараагийн аудитад дээрх асуудлуудыг давтан үзэх нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

⁶ .Аймаг, нийслэлийн жилийн төсвийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

⁷ тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

⁸ .тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сүхбаатар аймгийн Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 45,600.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 5,991.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

| /Сая төгрөгөөр/ | | | | | |
|-----------------|--|------------|-----------|---------|----------|
| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 53,230.8 | 50,965.8 | -4.3% | -2265.0 |
| 1.1 | Урсгал зардал | 45,600.0 | 44,721.6 | -1.9% | -878.4 |
| 1.2 | Хөрөнгийн зардал | 5,991.5 | 5,294.9 | -11.6% | -696.0 |
| 1.3 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 1,639.3 | 949.3 | -42.0 % | -690.0 |
| 2 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 53,230.8 | 50,965.8 | -4.3% | -2,265.0 |
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих | 30,293.7 | 30,233.4 | -0.2% | -60.3 |
| 2.2 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 17,033.7 | 16,275.0 | -4.5% | -758.7 |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 815.3 | 2,976.1 | 265.0% | 2,160.8 |
| 2.4 | Бусад эх үүсвэр | 5,088.1 | 1,481.3 | -70.9% | -3606.8 |

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага 50,965.8 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. ИТХ-аас төрөөс олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлын төсвийг батлаагүйгээс орон нутгийн байгууллагууд 8.2 сая төгрөгийг олгоогүй төсөвт төвлөрүүлсэн дүнгээр төсвийн зарлагын гүйцэтгэл дутуу илэрхийлэгджээ.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 2,841.8 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 2,841.8 сая төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

Хоёр. Санхүүгийн тайлангийн дансдын талаар

2.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

2.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төв орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын болон төсөл сангийн төгрөгийн болон харилцах дансдын үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгөний ажил гүйлгээнүүд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эхэнд 4,360.4 сая төгрөг байсан бол оны эцэст 2,883.4 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 0.2 хувь буюу 4.6 сая төгрөг кассанд, хувь 81.9 буюу 2,361.0 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 17.9 хувь буюу 517.8 сая төгрөг арилжааны банкинд байршиж байна. Арилжааны банкны үлдэгдлийн 0.02 хувь буюу 0.1 сая төгрөг нь төсөвт байгууллага, 4.2 хувь буюу 22.0 сая төгрөг нь төрийн сан, 95.78 хувь буюу 495.7 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл тус тус эзлэж байна.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Кассад байгаа бэлэн мөнгө | /сая төгрөгөөр/ | |
|----------------------------|----------------|-----------------|---------------------------|-----------------|-----------------------------|
| | | | | Арилжааны банк | Төрийн сангийн нэгдсэн данс |
| Кассад байгаа бэлэн мөнгө | 3.7 | 4.6 | | 4.6 | 0.04 |
| Төгрөг/ЖМС | 3.7 | 4.6 | | 4.6 | 0.04 |
| Гадаад валют | - | - | | | 4.6 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,356.7 | 2,878.8 | | 495.8 | 2,383.0 |
| Төгрөг | 4,356.7 | 2,877.8 | | 494.8 | 2,383.0 |
| Гадаад валют | | 1.0 | | 1.0 | |
| Нийт мөнгөн хөрөнгийн дүн | 4,360.4 | 2,878.8 | | 495.8 | 2,383.0 |
| Төсөвт байгууллага | 3,336.1 | 1,051.6 | 0.04 | 0.1 | 1,051.5 |
| Төсөл сангууд | | | | | |
| Төрийн сан | 787.1 | 1,331.5 | | 0.02 | 1,331.5 |
| ОНӨААТҮГ | 237.2 | 500.3 | 4.5 | 495.8 | 0 |

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл төрийн сангийн харилцах 46.2 хувь, төсөвт байгууллагын харилцах 36.5 хувь, орон нутгийн өмчит ААНБ-ын харилцах 17.3 хувийг тус тус эзэлж байна.

2.1.2 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой дараах алдаа зөрчил аудитаар илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд болон аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн сахилга, хариуцлагатай холбоотой нийт 313.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Эдгээр зөрчил дутагдал нь дээр дурьдсан 1.9.1, 1.9.2, 1.9.3 дахь асуудлуудад нэгтгэгдсэн болно. Нийт алдаа зөрчлөөс 150.4 сая төгрөгт акт тогтоож, 161.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, аудитын явцад 1.6 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залрууллаа.

2.2 Авлагын бүртгэл, тайлагнал

2.2.1 Авлагын бүтэц

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дансны нийт авлага 4,870.1 сая төгрөгөөр илэрхийлэгдэж өмнөх оноос 29.5 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын бүтцийг авч үзвэл: Дансны авлага /ТӨҮГ/, бусад байгууллага болон хувь хүмүүсээс авах авлага 5.9-115.4 сая төгрөгөөр буурч, бусад нэр төрлийн авлагууд 2.7-50.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /сая төгрөгөөр/ | |
|--|-------------------|--------------------|-------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 20.6 | 5.5 | -15.1 |
| Татаас, санхүүжилт | 146.1 | 148.8 | 2.7 |
| Зээлийн хүүгийн авлага | 28.0 | 42.8 | 14.8 |
| Дансны авлага /ТӨҮГ / | 716.8 | 601.4 | -115.4 |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ / | 41.4 | 33.7 | -7.7 |
| Бусад байгууллагаас авлага | 665.5 | 771.0 | 105.5 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 2913.5 | 2964.1 | 50.6 |
| Зээлийн авлага | 308.7 | 302.8 | -5.9 |
| Нийт дүн | 4840.6 | 4870.1 | 29.5 |
| Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал: | | | |
| Төсөвт байгууллага | 3844.1 | 3749.2 | -94.9 |
| Төсөл сангууд | | | |
| Төрийн сан | 106.3 | 106.4 | 0.1 |
| Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар | 890.1 | 1014.5 | 124.4 |

Нийт авлагыг байгууллагын төрлөөр авч үзвэл 77 хувийг төсөвт байгууллага, 2.2 хувийг төрийн сан, 20.8 хувийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага эзлэж

байна. Нийт авлагын дийлэнх хувийг төсөвт байгууллагын авлага эзлэж байгаа нь СХС-ийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүйгээс 3,225.5 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Мөн ОНӨҮГ-ууд нийт авлагын дүнд тодорхой нөлөөлөл үзүүлж байна. Айл өрх, албан байгууллагаас авах ус дулааны авлага 601.4 сая төгрөг буюу нийт авлагын 12.3 хувийг эзэлж байна.

2.2.2 Авлагын данстай холбоотой дараах алдаа зөрчил аудитаар илэрсэн байна. Үүнд:


- Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тайлан бүртгэлд тусгаагүй, төсвийн бодит бус хэмнэлтийг харилцагч байгууллага руу шилжүүлсэн, авлагыг насжилтаар ангилж толилуулаагүй, СХС-ийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлээгүй зэрэг нийт 1621.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Авлагын данстай холбоотой 3.3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 44.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 279.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 1293.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан байна.

2.3 БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

2.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 3,299.4 сая төгрөг байснаас тайлант онд 720.9 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 4,020.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Бараа материалын нэр төрлөөр нь авч үзвэл: түүхий эд материал 750.7 сая, хангамжийн материал 123.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нөөцийн бараа 153.4 сая төгрөгөөр буурсан байна.



■ Төсөвт байгууллага
■ ОНӨҮГ

Нийт бараа материалын 15 хувийг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 85 хувийг төсөвт байгууллага эзлэж байна.



2.3.2 Бараа материалын данстай холбоотой дараах алдаа зөрчил аудитаар илэрсэн байна. Үүнд:

Бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр бараа материалыг акталж

устгасан, орлого, зарлагыг аккруэл сууриар толилуулаагүй, тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн зэрэг нийт 1226.3 сая төгрөгийн алдаа илэрсэн. Эдгээр зөрчил дутагдал нь дээр дурьдсан 1.9.1, 1.9.2, 1.9.3 дахь асуудлуудад нэгтгэгдсэн болно. Бараа материалын данстай холбоотой 14.3 сая төгрөгийн 5 зөрчилд акт тогтоож, 124.7 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 369.6 сая төгрөгийн 20 алдаа дутагдалд зөвлөмж өглөө. Мөн аудитын явцад санхүүгийн тайланд 716.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

2.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

2.4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2017 оны эхэнд 121,496.2 сая төгрөг байсан бол 25,252.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,074.6 сая төгрөгөөр хасагдаж 144,674.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

/сая.төгрөгөөр/

| Ангилал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|---|------------------|------------------|-----------------|
| Барилга байгууламж | 80,201.3 | 82,383.10 | 2,181.80 |
| Тээврийн хэрэгсэл | 6,419.7 | 6,518.60 | 98.90 |
| Машин тоног төхөөрөмж | 13,602.4 | 14,447.20 | 844.80 |
| Тавилга эд хогшил | 4,883.2 | 5,080.70 | 197.50 |
| Түүх соёлын дурсгалт зүйлс | 1,066.5 | 1,080.00 | 13.50 |
| Дуусаагүй барилга байгууламж | 2,464.5 | 2,424.50 | -40.00 |
| Бусад үндсэн хөрөнгө | 11,940.3 | 31,758.70 | 19,818.40 |
| Номын фонд | 519.2 | 579.2 | 60.00 |
| Биет бус хөрөнгө | 92.7 | 95.9 | 1.00 |
| Зам, гүүрийн байгууламж | 306.3 | 306.3 | - |
| Бусад үндсэн хөрөнгө ТӨҮГ | 0.05 | 0.05 | - |
| Дүн | 121,496.2 | 144,674.3 | 23,178.1 |
| Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал: | | | |
| Төсөвт байгууллага | 86,389.3 | 89,921.6 | 3,532.3 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 35,106.6 | 54,752.7 | 19,646.1 |

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл өмнөх оноос 23,178.1 мянган төгрөгөөр өссөн бөгөөд дуусаагүй барилга байгууламж 40.0 сая төгрөгөөр буурч, бусад хөрөнгө 1.0 – 19,818.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн 62.1 хувийг төсөвт байгууллага, 37.9 хувийг төрийн өмчит үйлдвэрийн газар эзэмшиж байна.

2.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Тайлант хугацаанд элэгдлийн зардал 11,121.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,081.6 сая төгрөгийн элэгдэл данснаас хасалт хийгдэж, хуримтлагдсан элэгдэл 44,539.0 мянган төгрөг болсон байна.

2.4.3 Үнэ төлбөргүй авсан болон акталсан үндсэн хөрөнгө

Тайлант хугацаанд хандиваар 2,123.5 сая, бусад болон шилжүүлэн авсан 22,556.7 сая нийт 24,680.2 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч 1,004.7 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

2.4.4 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах нийтлэг зөрчил дутагдал илэрсэн байна.

Үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийж баримтжуулаагүй, тооллогын комисс чиг үүргээ хэрэгжүүлдэггүй, хөрөнгийн бүртгэлийг стандарт, журмын дагуу хийгээгүй, хөрөнгийг орлого авч данс бүртгэлд толилуулаагүй зэрэг 301.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Эдгээр алдаа зөрчилд 15.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэх албан шаардлага хүргүүлж, 272.6 сая төгрөгийн материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгч, 14.0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан байна. (Алдаа, зөрчлийн нэгтгэлийн хавсралтад дэлгэрэнгүй үзүүлэв.)

2.5. ӨР ТӨЛБӨРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 10,020.7 сая төгрөг байснаас тайлангийн эцэст 22,619.7 сая төгрөг болж, 12,559.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|--|-----------------|-----------------|-----------------|
| Богино хугацаат өр төлбөр | 5,626.6 | 18,141.2 | 12,514.6 |
| Ажиллагчидтай холбогдсон тооцоо | 179.0 | 165.8 | -13.2 |
| Богино хугацаат зээлийн өглөг | 1,454.6 | 756.4 | -698.2 |
| Бараа үйлчилгээний зардлын тооцоо | 55.6 | 18.7 | -36.9 |
| Урьдчилж орсон орлого | 1,187.5 | 14,332.6 | 13,145.1 |
| Бусад өглөг | 2,749.9 | 2,867.7 | 117.8 |
| Урт хугацаат өр төлбөр | 4,394.1 | 4,478.5 | 84.4 |
| Урт хугацаат зээл | 4,394.1 | 4,478.5 | 84.4 |
| Нийт өр, төлбөр | 10,020.7 | 22,619.7 | 12,599.0 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч | | | |
| Төсөвт байгууллага | 600.9 | 433.2 | -167.7 |
| Төсөл сангууд | 0.4 | 0 | -0.4 |
| Төрийн сан | 101.3 | 203.6 | 102.3 |
| Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар | 9,318.1 | 21,982.9 | 12,664.8 |

/сая төгрөгөөр/

Тайлант хугацаанд нийт өр төлбөр өмнөх оноос 125.7 хувь буюу 12,599.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: “Сүхбаатар тохижилт” ОНӨҮГ-ын санхүүгийн тайланд 13,145.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг санхүүгийн тайлан, тодруулгад НББОУС 20-д заасны дагуу урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн нь нөлөөлж байна. Мөн ажиллагсадтай холбогдсон өглөг 13.2 сая, богино хугацаат зээлийн өглөг 698.2 сая, бараа үйлчилгээний зардлын тооцоо 36.9 сая төгрөгөөр тус тус буурсан, урьдчилж орсон орлого 13145.1 сая, бусад өглөг 117.8 сая төгрөг, урт хугацаат зээл 84.4 сая төгрөгөөр тус тус өссөн.

Нийт өр төлбөрийг байгууллагын төрлөөр авч үзвэл 97.1 хувийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 2.0 хувийг төсөвт байгууллага, 0.9 хувийг төрийн сан эзлэж байна.

2.6 Орлого, татаас санхүүжилтийн талаар

2.6.1 Улсын төсвийн орлогын шилжүүлэг

Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 5,815.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгээр 1,554.8 сая төгрөг хуваарилахаар төлөвлөж, бүрэн санхүүжжээ.

2.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн төсвийг 2017 онд нийт 17,594.0 сая төгрөгөөр баталсанаас 16,926.5 сая төгрөгийн төсвийг санхүүжүүлж, гүйцэтгэлээр 16,723.3 сая төгрөг зарцуулж үлдэгдэл 203.2 сая төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрсөн байна. Санхүүжилтийг байгууллагаар нь авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Мөнгөн дүн | № | Байгууллагын нэр | Мөнгөн дүн |
|-----------------|----------------------|------------|-----------------|---------------------------|------------|
| 1 | Аймгийн ЗДТГ | 1,727.7 | 9 | Засаг дарга | 1,811.5 |
| 2 | Аймгийн ИТХ | 330.1 | 10 | Сумын ЗДТГ | 4,149.2 |
| 3 | Өмчийн газар | 144.1 | 11 | Сумын ИТХ | 636.0 |
| 4 | СХААлба | 134.1 | 12 | Халамжийн сан | 5,082.7 |
| 5 | Байгаль орчны алба | 389.6 | 13 | Орон нутгийн хөгжлийн сан | 1,735.0 |
| 6 | Хот тохижуулах газар | 283.8 | 14 | Байгаль хамгаалах сан | 85.0 |
| 7 | Ойн анги | 38.0 | 15 | Техник хяналт | 80.8 |
| 8 | Замын сан | 298.8 | 16 | | |
| НИЙТ ДҮН | | | 16,926.5 | | |

2.6.3 Өөрийн орлого

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлого нийт 710.3 сая төгрөгөөр батлагдаж 921.7 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Үүнийг байгууллагаар нь авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Мөнгөн дүн | № | Байгууллагын нэр | Мөнгөн дүн |
|-----------------------|-----------------------------|------------|----|---------------------------|------------|
| 1 | Аймгийн ЗДТГ | 10.0 | 7 | Сумын ЗДТГ | 25.9 |
| 2 | Аймгийн ИТХ | 0 | 8 | Халамжийн сан | 0 |
| 3 | Орон нутгийн өмчийн газар | 5.0 | 9 | Байгаль хамгаалах сан | 101.6 |
| 4 | Байгаль орчны алба | 7.0 | 10 | Орон нутгийн хөгжлийн сан | 27.8 |
| 5 | Боловсрол эрүүл мэндийн сан | 400.0 | 11 | Техник хяналтын зардал | 98.9 |
| 6 | Мал хамгаалах сан | 34.1 | | | |
| НИЙТ ДҮН 710.3 | | | | | |

2.6.4 Татварын орлого

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар:

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 7,184.2 сая төгрөгөөр, хүн амын орлогын албан татварын буцаан олголтонд 671.5 сая төгрөг олгохоор тооцож нийт татварын болон татварын бус орлогыг 11,723.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 7,726.8 сая төгрөг төвлөрч орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 107.5 хувийн биелэлттэй гарсан байна.

Татварын орлого давж биелэхэд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулсан, шонхор шувуу агнах зөвшөөрөл олгогдсон, үл хөдлөх хөрөнгийн худалдан борлуулах төлөгчийн тоо нэмэгдсэн зэрэг нь нөлөөлжээ.

Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээр давсан боловч татварын нэр төрлөөр нь авч үзвэл бууны албан татвар, хог хаягдал үйлчилгээний болон улсын тэмдэгтийн хураамж зэрэг 3 нэр төрлийн татвар, хураамж 80.4 сая төгрөг буюу 1.2-32.4 хувиар тасарсан байна.

Зарим нэр төрлийн орлого тасарсан шалтгааныг авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөөг бууруулсан, өөр аймгийн төсөвт төвлөрүүлсэн, бууны албан татвар төлөгчийн тоо бүртгэл зөрүүтэй байсан зэрэг нөлөөлжээ.

2.7 ЗАРЛАГЫН ТАЛААР

2.7.1 Урсгал зарлага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт урсгал зардалд 50,965.8 сая төгрөгийг зарцуулжээ. 2017 онд батлагдсан төсөвтэй харьцуулахад 95.7 хувийн гүйцэтгэл гарсан байна.

Нийт гүйцэтгэлийн 71 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 0.4 хувийг татаас, 16.4 хувийг урсгал шилжүүлэг, 10.4 хувийг хөрөнгийн зардал, 1.8 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлд тус тус зарцуулсан байна.

Төсвийн зарлагыг нэр төрлөөр нь харуулбал:

/сая төгрөгөөр/

| Зардлын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|--------------------------------------|------------|-----------|---------|
| Нийт урсгал зарлага | 53,230.8 | 50,965.8 | 2,265.0 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 36,919.5 | 36,192.0 | 727.5 |
| Татаас | 186.5 | 186.5 | - |
| Урсгал шилжүүлэг | 8,494.0 | 8,343.1 | 150.9 |
| Хөрөнгийн зардал | 5,991.5 | 5,294.9 | 696.6 |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл | 1,639.3 | 949.3 | 690.0 |

2.7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний харьяаны төсвийн захирагч нарын нэмэлт санхүүжилтийн дансаар 2,841.8 сая төгрөгийн орлого орж, 2,514.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 327.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийг сайдын багцаар нь авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нэмэлт санхүүжилтийн орлого | Нэмэлт санхүүжилтийн зарлага | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдэл |
|------------------|-----------------------------|------------------------------|--|
| 1 ЭМЯ | 56.6 | 56.6 | - |
| 2 БСШУСЯам | 217.8 | 214.5 | 3.3 |
| 3 ХНХЯам | 129.0 | 129.0 | - |
| 4 БХБЯам | 7.6 | 7.6 | - |
| 5 Орон нутаг | 2,430.8 | 2,106.4 | 324.5 |
| ДҮН | 2,841.8 | 2,514.1 | 327.7 |

2.7.3 Тусгай шилжүүлгийн зарцуулалт

Тусгай зориулалтын шилжүүлгээр 28,738.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч, төсвийн зардалд 28,678.6 сая төгрөг зарцуулжээ. Улсын төсөвт 60.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Хүснэгтээр илэрхийлвэл:

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт мөнгөн гүйлгээний зарлагын дүн | Үүнээс | | | | | |
|------------------|-------------------------------------|----------------------------|--------------------------------------|-------|------------------------------|-----------------------------------|-------------------------------|
| | | авлага тооцож төвлөрүүлсэн | Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн | Бусад | Нэмэлт санхүүжилтийн зарлага | Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн | Тусгай шилжүүлгээр зарцуулсан |
| 1 ЭМЯ | 3,518.6 | | 12.9 | 20.6 | 56.6 | | 3,428.5 |

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

| | | | | | | | | |
|---|------------|-----------------|--|-------------|--------------|--------------|------------|-----------------|
| 2 | БСШУСЯам | 25,504.5 | | 44.2 | 357.7 | 214.5 | 3.3 | 24,884.8 |
| 3 | ХНХЯам | 290.1 | | | 6.3 | 128.9 | | 154.9 |
| 4 | БХБС | 276.2 | | 3.2 | 55.0 | 7.6 | | 210.4 |
| | ДҮН | 29,589.4 | | 60.3 | 439.6 | 407.6 | 3.3 | 28,678.6 |

2.8 Хуримтлагдсан үр дүнгийн талаар

Тайлант хугацаанд хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдэл 25,528.4 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 426.0 сая, тайлант үеийн үр дүн 1,671.0 сая төгрөгөөр тус тус буурч нийт хуримтлагдсан үр дүн 23,431.4 сая төгрөг болжээ.

2.9 Эзэмшигчийн өмчийн талаар

Засгийн газрын оруулсан капиталын эхний үлдэгдэл 91,083.3 сая төгрөг, засгийн газрын оруулсан капитал 356.4 сая төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан үр дүн 2,097.0 сая, дахин үнэлгээний нөөц 0.04 сая төгрөгөөр тус тус буурч засгийн газрын хувь оролцооны нийт үр дүн 89,342.6 сая төгрөг болжээ.

3 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа төсвийн захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

ТЕЗ-ын харьяаны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит ААНБ-ууд, төсөл сангуудын нийт 96 санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөр төлөвлөсөнөөс 84 тайланд “Зөрчилгүй”, 11 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 1 тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа. *(Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагыг жагсаалтаар гаргаж Хавсралт 5-д харуулав.)*

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 6,934.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүний 2459.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 251.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 3,317.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч 905.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлжээ.

4. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 04.19-ний өдрийн 6/552 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

5. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх санал дүгнэлт:

Бид Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,563.0 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн, энэ нь бид бүхний олж тогтоосон материаллаг түвшнээс 1,415.8 сая төгрөгөөр хэтэрсэн, орон нутгийн төсвийг хэтрүүлэн зарцуулсан, төсвийн гүйцэтгэлийг дутуу тайлагнах нөхцөл байдал үүссэн, сумдын төсвийн ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг холбогдох заавар журмын дагуу толилуулаагүй, төсөвт хохирол учруулсан байх гэмт хэргийн шинж чанартай зөрчил дутагдал илэрсэн, Эмийн эргэлтийн сангийн орлого, зарлага аудитаар баталгаажаагүй, 5 төсвийн шууд захирагч, 1 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан, 4 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд стандарт бус санал дүгнэлт өгсөн нь аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл болж байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил, бүртгэлийн тодорхойгүй нөхцөл байдлуудыг эс тооцвол Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт өгөхийг Аймгийн тэргүүлэх аудиторт санал болгож байна.

6. ҮАГ болон Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна.

ҮАГ-ын САГ-т санал:

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн элсэлтийн тоо буурсантай холбогдуулан цагийн багшгүй болсон, багшийн багц цаг багассан, илүү цаггүй болсонтой холбоотойгоор цалингийн сан 2017 онд 13.9 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг илүү төлөвлөснөөс 2016, 2017 онуудад тус бүр 24.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн, хоолны хүнсний зардал буюу дотуур байрны нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг хэтэрүүлэн 14.1 сая төгрөгөөр илүү зарцуулсан. Иймд тус байгууллагын цалин хөлсний төсвөөс 13.9 сая, түлш халаалтын зардлаас 12.0 сая, хоол хүнсний зардлаас 14.1 сая нийт 40.0 сая төгрөгөөр төсвийг танах боломжтой байна.

Сангийн яаманд санал:

Аймгийн ТЕЗ-ын төсвийн төсөл боловсруулах үйл явц, төсвөө батлаагүй нөхцөл байдал үүсэх, Төрийн аудитын байгууллагаас хийсэн дээрх дүгнэлтүүдтэй уялдуулан зөрчил дутагдлыг арилгах хүртэл хугацаанд Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.3.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг санал болгож байна.


7. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ


Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АОУС-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,563.0 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн. Энэ нь бид бүхний олж тогтоосон материаллаг түвшнээс 1,415.8 сая төгрөгөөр хэтэрсэн, орон нутгийн төсвийг хэтрүүлэн зарцуулсан, төсвийн гүйцэтгэлийг дутуу тайлагнах нөхцөл байдал үүссэн, сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг холбогдох заавар журмын дагуу толилуулаагүй, төсөвт хохирол учруулсан байх гэмт хэргийн чанартай зөрчил дутагдал илэрсэн. Эмийн эргэлтийн сангийн орлого, зарлага аудитаар баталгаажуулгаагүй, 5 Төсвийн шууд захирагч, 1 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан, 4 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд стандарт бус санал дүгнэлт өгсөн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Дээрх зөрчил дутагдал нь материаллаг шинжтэй боловч санхүүгийн нэгтгэсэн тайланд өргөн тархаагүй гэж дүгнэсэн болно.


Иймд Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл ажил, гүйлгээнүүд нь холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв шударга илэрхийлээгүй тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР  М.НАРАНТУЯА
Г.ДАВАА

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР АУДИТОР  Н.БОЛДБААТАР
А.МӨНХЦЭЦЭГ
Б.МӨНХБАМБАР
О.БАРЧИДГҮНСЭН
Ө.ЗОЛЗАЯА

Сүхбаатар аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн санал :


МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

2018.05.07 № 2167

танай _____-ны № _____-т

Санал тайлбар хүргүүлэх тухай

Сүхбаатар аймгийн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн аудитын дүгнэлт болон зөвлөмжийн төсөлтэй танилцаад дараах тайлбар саналыг хүргүүлж байна.

2016 оны сонгуулийн үр дүнгээр 2 намын суудал тэнцэж аймгийн засаглалын үйл ажиллагаа төрийн ажлыг явуулахад байнгын хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар ирсэн билээ. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тодорхой шийдвэрүүдийг гаргах, төрийн ажлыг тасралтгүй хэвийн явуулах, аймаг орон нутагт тулгамдаад байгаа олон асуудлуудыг шийдэх, ард иргэдийн аятай тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, цаг үеийн шинжтэй олон асуудлуудыг цаг алдалгүй шийдэх зайлшгүй шаардлага гарсан. Иймд эдгээр асуудлуудад анхаарлаа хандуулж өөрийн дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн хүрээнд тодорхой захирамж шийдвэрүүдийг гаргаж төрийн ажлыг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Засаг даргын орлогч миний бие нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд өгсөн санал дүгнэлттэй уншиж танилцаад зарим зүйлтэй санал нийлэхгүй байгаа учир дараах тайлбаруудыг хүргүүлж байна. Эдгээр тайлбар нь та бүхний дүгнэлтийг 100 хувь үгүйсгэсэн явдал биш бөгөөд эцсийн дүндээ аймаг орон нутгийн хөгжил дэвшил, ард түмний сайн сайхан амьдрал, аятай тухтай ажиллаж хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хийсэн үйлдэл гэж үзэн хамтран ярилцаж, ойлголцож зөв талаас нь харж санал дүгнэлтэндээ тусгана гэж найдаж байна.

Аудитын дүгнэлтийн 1.7-д дурдагдсан төсвийн тухай хуулийг зөрчиж төсвийн түр горимыг буруу хэрэгжүүлсэн, хүчин төгөлдөр бус тогтоол шийдвэрээр 695,8 сая

0000240

төгрөгийн төсвийг батлуулалгүйгээр төсөв хэтрүүлэн зарцуулсан байна гэж. УИХ-аас 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 2017 оны төсвийн тухай хуульд тодотгол хийж уг тодотголоор манай аймагт өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 207,6 сая төгрөг, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн иргэдэд төрөөс олгох тэтгэмжийн зардалд 282.5 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж 156,9 сая төгрөг, хүнс тэжээлийн хөнгөлөлт гэж 82,0 сая төгрөг нийт 729,0 сая төгрөг санхүүгийн дэмжлэгт нэмж батлагдан хуваарилагдаж ирсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 2017 оны төсөвт тодотгол хийлгэх тухай төсвийн төслийг боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, мөн 12 сарын 6-ны өдөр нийт 2 удаа хүргүүлсэн боловч улс төрийн нөхцөл байдлын улмаас хоёр нам үл ойлголцолд хүрч төсөв хэлэлцэх асуудал удаа дараа хойшлогдсон. 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 5 дугаар хуралдааныг үргэлжлүүлж төсвийн төслийг хэлэлцүүлэхээр товлосон боловч АН-ын бүлгийн 16 төлөөлөгч хуралдаанд ирээгүй тул МАН-ын 16 төлөөлөгч төсвийг хэлэлцэн шийдвэр гаргасан. Үүний дагуу аймгийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд 12 дугаар сарын 22-ны өдөр А/699 дугаар захирамжаар дээрх зардлуудыг санхүүжүүлсэн болно. Эдгээр зардлууд нь улсын нэгдсэн төсөвт батлагдаж төсвөөс санхүүжсэн дүн бөгөөд өвс тэжээлийн нөөцөд 20,0 сая төгрөг, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдад 205,1 нийт 225,1 сая төгрөгийг зарцуулсан.

Удирдлагыг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 1800,0 сая төгрөг зарцуулаагүй 1600,0 сая төгрөгийг баталсан. Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх боломжгүй хөрөнгө оруулалтын шинж чанартай, хуульд заасан ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор тодорхой хэмжээний төсвийг батлуулдаг. 2017 оны 02 дугаар сарын 16-нд удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг батлуулахдаа 3 бүлэгт хувааж батлуулсан. 1 дүгээрт ажлын байр нэмэгдүүлэх үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт 1000,0 сая төгрөг, 2 дугаарт Малын үүлдэр угсааг сайжруулах малжуулах хөтөлбөрт 200,0 сая төгрөг, 3-дугаарт боловсрол эрүүл мэнд болон нийгмийн бусад салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 400,0 сая төгрөгийг тус тус батлуулсан боловч зарим ажлыг нь тухайн ондоо хэрэгжүүлэх боломжгүй болсон.

Тиймээс 2017 оны төсвийн тодотголоор зарим зардлыг хасаж цаг үеийн шинжтэй, аймаг орон нутагт тулгамдаад байгаа шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай ажлуудыг оруулахаар тооцож саналыг төсвийн ерөнхийлөн захирагч ИТХ-д санал оруулсан. Үүнд бүх сумдад хийгдэх малын үүлдэр угсааг сайжруулах малжуулах төслийн санхүүжилтийг

бууруулах, Боловсрол эрүүл мэнд болон бусад салбарын хөгжлийг дэмжих зардал 400,0 сая төгрөгийг 120,0 сая төгрөгөөр бууруулан иргэд байгууллагуудаас ирүүлсэн санал, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах /хур тунадас өмнөх жилүүдээс ахиу орсон/ зэрэг зайлшгүй шийдэх шаардлагатай асуудлуудыг харгалзан үзэж засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж Засаг дарга захирамж гарган дараах зардлуудыг санхүүжүүлсэн болно.

Тухайлбал: Баруун-Урт сумын иргэдийг хэрэглээний халуун усаар хангах зардлын зөрүү 56,6 сая төгрөг, Дөрвөлж ОНӨҮГ-ын хэвийн үйл ажиллагааг хангахад усны үнийн зөрүү 80,0 сая төгрөг, Түмэнцогт сумын Ус дулаан ОНӨҮГ-ын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах уурын зуухны халаалтын тогоог шинэчлэхэд шаардлагатай 39,8 сая төгрөг, Наран сумын төвлөрсөн халаалтын уурын зуухны тогоо хагарч байгууллагуудын халаалтыг өгч чадахгүй нөхцөл байдал үүссэний улмаас уурын зуухны тогоо авахад дэмжлэг болгож 6,7 сая төгрөг, аймаг байгуулагдсаны 75 жилийн ой, Баруун-Урт сумын 60 жил, Зүүн бүсийн хурд баяр наадмын зардалд 100,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Аудитын дүгнэлтийн 1.9.1, 1.9.2- т дурдагдсан асуудлуудын хувьд манай санхүү, төрийн сангийн хэлтсийн зүгээс хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмыг хэрэгжүүлэх талаар төсвийн эрх захирагч болон нягтлан бодогч нарт удаа дараа шаардалга тавьж сургалт семинар зохион байгуулдаг боловч тухайн байгууллагуудын удирдлага тавьсан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлдэг, төсөв захирагч нар болон нягтлан бодогчийн мэдлэг чадвар, санхүүгийн сахилга бат харилцан адилгүйгээс хариуцсан ажлаа мэргэжлийн өндөр түвшинд хангалттай гүйцэтгэж чадахгүй байгаа, мөн шат шатны төсөв захирагчид бүртгэл тооцооны ажилтануудын ажлын хариуцлагагүй байдал, мөн шат шатандаа хариуцлага тооцдоггүй зэргээс шалтгаалж жил бүрийн аудитын дүгнэлтэд эдгээр алдаа зөрчлүүд байнга давтагдан гарсаар байна. Бидний хувьд эдгээр алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрч байгаа ч зөрчийг давтан гаргуулахгүй байх, арилгуулах талаар та бүхэнтэй болон Санхүү хяналт аудитын албатай хамтран ажиллах болно.

1.9.3-т албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг холбогдох дээд шатны захирагчид хүргүүлсэн гэж дурдагджээ. Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн хувьд төсвийн эрх захирагчийн гаргасан зарим нэг тушаал, захирамж шийдвэр нь хууль тогтоомжид нийцэхгүй байгаа талаар байгууллагын удирдлагад бичгээр мэдэгдэж байсан ч гаргасан шийдвэрээ өөрчлөх боломжгүй гэдгээ бичгээр мэдэгдэж байсан тул Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн

294 тоот тушаалын 4.3.9 дэх заалтыг үндэслэн төсвийн эрх захирагчийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Аудитын дүгнэлтийн 1.9.6-т дурдагдсан асуудал 2017 онд тухайн байгууллагын хувьд хэмнэгдэж байгаа тооцоо гарсан хэдий ч 2018 оны тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд багш нарын үр дүнгийн урамшууллыг 30 хувьд олгох гэсэн Монгол улсын засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 345 тоот тогтоолоор үр дүнгийн урамшил нь 2018 оны төсөвт нэмж тусгагдаагүй батлагдсан төсөвтөө багтааж зохицуулалт хийхээр байгаа тул тухайн байгууллагууд дээр хэмнэгдэж байгаа зардлыг тооцон үзэж татан авч багш нарын үр дүнгийн урамшуулалд өгөхөөр тооцож байна. Тиймээс дээрх халаалт болон хоолны зардал хэмнэгдэхээр тооцоо гарахгүй байгаа юм.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн материаллаг алдааны дүнг тооцохдоо үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 2 хувиар тооцож гаргасан нь төвлөрүүлэн захирагчийн дүнд устгах бичилт хийгдээгүй дүнгээс тооцсон, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн материаллаг алдааг үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцохдоо устгалт хийсэн дүнгээр тооцож байгаа нь төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн материаллаг алдаа харилцан адилгүй төсвийн захирагч тус бүрийн дүнд өөр өөрөөр нөлөөлж байна гэж үзэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн материаллаг алдааны дүнд сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт дийлэнх хувийг эзэлж байгаа юм.

Тухайлбал Баяндэлгэр, Түмэнцогт, Онгон, Баруун-Урт, Мөнххаан, Эрдэнэцагаан, Сүхбаатар зэрэг сумдын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нийт 534,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа юм. 2017 онд хувьд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажилласан. Нийт сумдаас зээлийн эргэн төлөлтийн талаар 3 удаа судалгаа авч, хугацаа хэтэрсэн зээлдэгчид мэдэгдэл өгч улмаар шүүх хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, олгосон зээлийн чанар, ашиглалтад сумдад аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулан тодорхой удирдамжийн дагуу ажиллаж холбогдох хүмүүстэй уулзаж үүрэг чиглэл өгч зээлийг барагдуулах талаар төсвийн эрх захирагч нарт удаа дараа үүрэг даалгавар өгч ажилласан.

Иймд дээрх шалтгаан тайлбаруудыг үндэслэн материаллаг алдааг устгалт хийгээгүй дүнгээс тооцон үзэж сум хөгжүүлэх сангийн 534,5 сая төгрөг, засаг даргын хөтөлбөр үйл ажиллагааны арга хэмжээний зардлын 695,8 сая төгрөг, Уулбаян сумын

төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд хөрөнгө бараа материалыг эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн 21,2 сая төгрөгийг алдаа зөрчлөөс хасуулах саналтай байна.

Аудитаар илэрсэн бусад зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд дүгнэлтэд дурдсан зөрчлийг арилгах давтан гаргуулахгүй байх, холбогдох албан тушаалтнуудын эрх зүйн мэдлэг, ажил хариуцах чадвар санхүүгийн сахилга батыг сайжруулах, хариуцлага алдсан албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэх зэргээр хууль тогтоомж болон зөвлөмжийг хэрэгжүүлэн та бүхэнтэй хамтарч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.АМАРБААТАР

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

ТЕЗ-ийн ирүүлсэн саналаас **1.9.5**-д бичигдсэн 14 хуудасны дээрээсээ 7-р мөрөнд 207.6 сая төгрөгийг 20.0 сая төгрөг, 13-р мөрөнд 695.8 сая төгрөгийг 508.2 сая төгрөг болгон өөрчилж, зөрүү 187.6 сая төгрөгийг нийт алдаа зөрчлөөс хассан болно. Бусад саналын хувьд аудитын дүгнэлттэй санал нэг байгаа гэж үзэн тайлбар хийх шаардлагагүй гэж үзлээ..

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор:

М.Нарантуяа

Утас: 70518396, 99029193

Цахим хаяг: *naraa.m@audit.gov.mn*

Аудитын менежер: *Г.Даваа*

Утас: 70512123, 99035990

Цахим хаяг: *davaa.g@audit.gov.mn*

Ахлах аудитор: *Н.Болдбаатар*

Утас: 70512127, 93059399

Цахим хаяг:

boldbaatar.n@audit.gov.mn

Сүхбаатар аймгийн аудитын газрын хаяг:

Аймгийн Засаг даргын тамгын газрын байр 226, 225 тоот

Цахим хуудас:

<http://audit-sb.webs.com/>

СҮХБААТАР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйл:

Төсвийн төлөвлөлт, орлого28

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйл:

Санхүүгийн тайлангийн тодруулга, дотоод хяналт 29

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйл:

Төсвийн зарцуулалт, тайлагнал 30-31

8. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Төсвийн төлөвлөлт, орлого

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ № 1

ТАГ-ын ажиглалт

8.1.1 Аймгийн Засаг дарга 2017 оны төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.6.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.2.11, 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангаагүй толилуулсан, мөн аймгийн ИТХ тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, 33 дугаар зүйлийн 33.2.5 дахь заалтыг баримтлаагүй төсвийг баталсан байна

8.1.2 Сумдын ТТЗ нар Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2¹-д заасны дагуу төсвийн тодотгол хийх нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлохгүйгээр 362.6 сая төгрөгийн орлого, зарлагыг тодотгосон нь тус хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна. Мөн тодотгол хийхэд уг хуулийн 67 дугаар зүйлийн 67.2¹-д заасны дагуу төсвийн танилцуулгыг бүрэн боловсруулж тодруулаагүй, төсвийн иж бүрэн бүрэлдэхүүнийг хангаагүйгээр төсвийг өргөн барьж байна.

8.1.3 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийг баталсан боловч тухайн жилд хэрэгжүүлэх аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг баталсан тогтоол шийдвэр нь хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болохыг тогтоожээ.

Хариуцах ажилтан

Засаг даргын орлогч Т.Амарбаатар
СТСХ-ийн дарга М.Төмөрчулуун
Ерөнхий нягтлан бодогч Б.Одончимэг

Зөвлөмж

8.1.1 Төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь төлөвлөж, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу төсвийг иж бүрэн боловсруулж байх

8.1.2 Төсвийн тодотгол хийхдээ Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 д заасан нөхцөл байдал, шалтгаан, үр дагаварыг үнэн зөв тодорхойлж, тус хуулийн 67 дугаар зүйлд заасан танилцуулга, 32 дугаар зүйлд заасан шаардлагуудыг бүрэн боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр Сумдын ТТЗ түүний харьяаны төсөвт албан байгууллагуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мөн сумдын Санхүүгийн албаны даргыг Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтанд хамруулж, ур чадварыг нь дээшлүүлэх

8.1.3 Аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг хууль тогтоомжид заасны дагуу өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн Төсвийн болон МУЗЗНДНТУТ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, ДОТООД ХЯНАЛТ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ТАГ-ын ажиглалт

8.2.1 Бүх шатны төсвийн захирагч нар төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс дээр дурьдсан зөрчил дутагдлууд гарч байна.

8.2.2 Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаагүй “Мал хамгаалах сан”, “Байгаль хамгаалах” сангууд нэгтгэгдэж байна. Иймд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5⁹-д заасны дагуу дээрх сангуудыг ТЕЗ-ийн аль нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлж, нэгтгэх шаардлагатай байна.

Хариуцах ажилтан

Засаг даргын орлогч Т.Амарбаатар
СТСХ-ийн дарга М.Төмөрчулуун
Ерөнхий нягтлан бодогч Б.Одончимэг

Эрсдэл

Зөвлөмж

8.2.1 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу бүх шатны төсөв захирагч, төсвийн байгууллагуудад дотоод хяналт хийх журмыг боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол үе шаттай хяналтыг хэрэгжүүлэх

8.2.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5¹⁰-д заасны дагуу дээрх сангуудыг ТЕЗ-ын аль нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулан нэгтгэж, тус сангуудыг татан буулгах. Эдгээр сангууд нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиудтай нийцэхгүй байгаа болно.

Төсвийн захирагчийн хариу

⁹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

ТАГ-ын ажиглалт

8.3.1 Сүхбаатар аймгийн ТЕЗ-ын төсвийн жил эхлэхэд аймгийн ИТХ-аар төсвөө батлуулаагүй нөхцөл байдал үүссэн. Иймд төсвийн санхүүжилтийн түр горимыг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан боловч Төсвийн тухай хуулийн 41.4.1, 41.4.2 дахь заалтуудыг мөрдөлгүй цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг өмнөх оны түвшинд санхүүжүүлэхийг захирамжилсан нь уг хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн. Манай байгууллагаас дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй байхад 1,169.6 сая төгрөгийн төсвийг 2017 оны 01 дүгээр сард зарцуулж, Төсвийн тухай хуулийг зөрчсөн.

8.3.2 Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд 1600.0 сая төгрөг баталсан. Удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр нэг бүрчлэн баталж өгөөгүйгээс нэг удаагийн шинж чанартай дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулал олгох, уралдаан тэмцээний үйл ажиллагаанд 680.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуульд нийцээгүй байна. Мөн удирдлагыг хэрэгжүүлэх зардалд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгосон 500.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл батлагдсан байдаг бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.8¹¹ дахь заалттай нийцээгүй бөгөөд зарлагаар баталсан нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна

8.3.3 Сумдын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Эмийн эргэлтийн санг нэгтгэн толилуулсан байна. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3.1-д заасны дагуу ТЕЗ-чид хамаарах бүх төсвийн байгууллага, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг хамруулахаар заасан байдаг. Гэтэл сумын ЭЭС-

Зөвлөмж

8.3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй нөхцөл байдал үүсвэл Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн түр горимыг зөв хэрэгжүүлж ажиллах

8.3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр, арга хэмжээ нэг бүрээр төлөвлөн, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 31 дүгээр зүйлийн 31.1, 33 дугаар зүйлийн 33.2.8¹² дахь заалтуудыг мөрдөх ажиллах. Мөн Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох журам”-ын 2 дугаар хавсралт 1.2.3-т орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг тодорхойлсон байна. Эндээс дүгнэж үзэхэд орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардал тусдаа хөтөлбөр, арга хэмжээ болох боломжгүй харагдаж байгаа бөгөөд цаашид нэгтгэх шаардлагатай гэж үзэж байна.

8.3.3 Сумын ТТЗ-ийн нэгтгэлд Эргэлтийн эмийн сан нэршлийн дор улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн /ХХК/ тайланг нэгтгэж байгаа байдлыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын хавсралт журмын 3.2, 3.3, 3.4, УСНББОУС-6 ийн 39 дүгээр заалтад нийцүүлэн судалж, сумын ТТЗ-ын эрх

¹¹ төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр

¹² төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр

ууд нь хувьд шилжсэн, ХХК нэршлээр улсын бүртгэлд бүртгэгдсэн нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын хавсралт журмын 3.2, 3.3, 3.4, УСНББОУС 6-ын 39 дүгээр заалтад заасны дагуу сумын ТТЗ-ийн эрх мэдэл, хяналтад байх чадамжгүй байгаа бөгөөд дээрх дүнгээр ТЕЗ-ийн нэгтгэл үнэн зөв толилуулагдаагүй байна.

Хариуцах ажилтан

Засаг даргын орлогч Т.Амарбаатар
СТСХ-ийн дарга М.Төмөрчулуун
Ерөнхий нягтлан бодогч Б.Одончимэг

Эрсдэл

мэдэл, хяналтад байх боломжгүй байгаа байдлыг тодорхойлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Жич: Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 25-ны дотор гаргаж ирүүлэх

9. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 12,503,874,520.48 | 11,827,039,967.62 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | | |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 4,360,391,907.39 | 2,883,420,782.46 |
| 31110 | Төгрөг | 3,674,054.79 | 4,609,946.42 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,356,717,852.60 | 2,878,810,836.04 |
| 3121 | Төгрөг | 4,356,624,304.41 | 2,877,784,243.97 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,027,881,742.18 | 2,361,011,278.73 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 328,742,562.23 | 516,772,965.24 |
| 3122 | Гадаад валют | 93,548.19 | 1,026,592.07 |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 93,548.19 | 1,026,592.07 |
| 33 | АВЛАГА | 4,840,667,141.08 | 4,870,101,611.80 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 20,622,142.55 | 5,563,589.09 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 146,092,402.00 | 148,832,902.00 |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | 27,988,560.00 | 42,768,501.11 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 716,853,850.38 | 601,400,777.30 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 41,374,783.37 | 33,725,898.96 |
| 335 | Бусад авлага | 3,579,030,471.78 | 3,735,097,637.34 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 665,573,412.25 | 770,960,892.70 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,913,457,059.53 | 2,964,136,744.64 |
| 336 | Зээлийн авлага | 308,704,931.00 | 302,712,306.00 |
| 3361 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 308,704,931.00 | 302,712,306.00 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 308,704,931.00 | 302,712,306.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 3,338,757.00 | 53,224,343.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 1,738,757.00 | 29,061.00 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 1,600,000.00 | 53,195,282.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | | 53,075,282.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 1,600,000.00 | 120,000.00 |

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

| | | | |
|------------|------------------------------------|--------------------------|---------------------------|
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | | |
| | | 3,080,123,554.03 | 3,954,389,037.96 |
| 351 | Түүхий эд материал | | |
| | | 215,692,114.95 | 251,809,062.22 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 99,438,352.73 | 122,679,336.73 |
| 35130 | Эм боох материал | 116,253,762.22 | 129,129,725.49 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | 716,832,051.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,881,910.00 | 635,088.00 |
| 354 | Хангамжийн материал | | |
| | | 2,625,621,061.13 | 2,732,120,958.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 74,469,740.94 | 76,566,376.19 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,478,485,488.15 | 1,416,221,617.01 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 54,176,958.06 | 60,330,211.07 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 77,435,669.27 | 66,876,418.26 |
| 35450 | Барилгын засварын материал | 23,534,492.00 | 34,620,624.00 |
| 35460 | Хүнсний материал | 227,197,484.60 | 88,611,433.31 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 690,321,228.11 | 988,894,278.95 |
| 35600 | Мал амьтад | 235,928,467.95 | 252,991,877.95 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| | | 219,353,160.98 | 65,904,192.40 |
| 36100 | Барааны нөөц | 219,244,580.98 | 65,904,192.40 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 108,580.00 | |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 88,600,186,934.54 | 100,135,280,709.74 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 88,600,186,934.54 | 100,135,280,709.74 |
| 392 | Биет хөрөнгө | | |
| | | 88,572,012,944.75 | 100,111,196,465.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 80,201,266,327.06 | 82,383,066,350.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (18,209,496,057.96) | (20,593,570,872.38) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 6,419,664,596.12 | 6,518,640,103.95 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,245,185,850.39) | (3,816,091,835.32) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 13,602,436,964.44 | 14,447,188,776.41 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (5,992,260,081.93) | (7,358,790,714.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 4,883,189,255.95 | 5,080,687,748.07 |

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

| | | | |
|-------------|--------------------------------------|----------------------------------|----------------------------------|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (2,330,686,828.97) | (2,723,809,246.47) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 306,308,600.00 | 306,308,600.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (29,000,000.17) | (38,221,174.45) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,066,471,870.60 | 1,080,041,870.60 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,940,343,193.47 | 31,758,713,078.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,024,741,125.03) | (9,936,626,094.89) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 2,464,499,990.00 | 2,424,499,990.00 |
| 39217 | Ном | 519,202,091.56 | 579,159,885.86 |
| 393 | Биет бус хөрөнгө | 28,128,714.79 | 24,038,969.19 |
| 39301 | Програм хангамж | 65,045,248.77 | 67,245,248.77 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (53,861,820.18) | (59,495,931.91) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,739,521.00 | 28,729,521.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (10,794,234.80) | (12,439,868.67) |
| 394 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 45,275.00 | 45,275.00 |
| 39405 | Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ | 45,275.00 | 45,275.00 |
